


МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 1000

Улаанбаатар хот

Г Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн
дүрэм батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
2. Тушаалыг хэрэгжүүлэхэд удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буяントогтох/, Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл /Д.Мягмарцэрэн/-д тус тус даалгасугай.
3. Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг мөрдүүлж, мэргэжлийн арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



141211040

Эрүүл мэндийн сайдын 2021 оны
04 дугаар сарын 15-ний өдрийн
дугаар тушаалын хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг зүйл.

- 1.1 Өрхийн эрүүл мэндийн төв нь (цаашид “төв” гэх) хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий, сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна.
- 1.2 Төв нь үйл ажиллагаандaa Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль болон тэдгээрийн холбогдох бусад хууль тогтоомж, “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт” болон энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана.
- 1.3 Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн төвийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна.
- 1.4 Нөхөрлөлийг үүсгэн байгуулах, өөрчлөх, нэгтгэх, татан буулгахтай холбоотой харилцааг Нөхөрлөлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрхзүйн актаар зохицуулна.
- 1.5 Төв нь улсын бүртгэлд бүртгүүлэн, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.
- 1.6 Төв нь оноосон нэртэй байх бөгөөд албан ёсоор баталгаажсан тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.7 Өрхийн эрүүл мэндийн төвд ногдох иргэний доод хязгаар нь аймаг орон нутагт 6000-аас, нийслэлд 8000-аас доошгүй байна.
- 1.8 Төв нь улс төрийн үйл ажиллагаанаас анgid байж зөвхөн мэргэжлийн үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Төв байгуулах, төрөөс хяналт тавих өрөнхий чиг үүрэг.

- 2.1 Төвийг байгуулах байршил, хүрээг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлого, төлөвлөлтийн хүрээнд тухайн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.
- 2.2 Төвийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 2.3 Төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

-
- 2.4 Төвийн гэрээний гүйцэтгэлд гэрээний шалгуур үзүүлэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга/Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний багц, санхүүжилтэд хяналт тавин гэрээг дүгнэнэ.
- 2.5 Төвийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, нийслэлд Дүүргийн эрүүл мэндийн төвүүд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

Гурав. Төвийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага

- 3.1 Төв нь "Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа"-ны стандартад заасан бүтэцтэй байна.
- 3.2 Төвийн хүн амд эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зориулалтын эмнэлгийн байраар хангах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарын хамтран байгуулсан гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.
- 3.3 Нөхөрлөлийн хэлбэрээр байгуулагдсан төв нь дараах зохион байгуулалттай байна.
- 3.3.1 Тухайн төвд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтний 70-аас доoshгүй хувь нь нөхөрлөлийн гишүүн байна.
- 3.3.2 Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал байна.
- 3.3.3 Хурлын шийдвэр нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд гишүүдийн олонхи дэмжих гаргасан, бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулж, шийдвэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хамтран хариуцна.
- 3.3.4 Нөхөрлөлд гишүүнээр элсэх, гишүүнээс татгалзах асуудлыг Нөхөрлөлийн тухай хуулиар зохицуулна.
- 3.3.5 Нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаас тус төвийн удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүнийг томилж, чөлөөлнө.
- 3.3.6 Төвийг удирдах эрх бүхий гишүүн нь хүний их эмчийн мэргэжил эзэмшсэн, тухайн ӨЭМТ-д мэргэжлээрээ 5-аас доoshгүй жил ажилласан, мэргэжлийн болон удирдахуйн ур чадвартай, хамт олны дунд нэр хүндтэй, багаар ажиллах чадвартай хүн байна. Удирдахуйн ухаанаар суралцсан болон өрхийн анагаах ухаанаар мэргэшсэн бол давуу тал болно.
- 3.3.7 Төвийн удирдлага нь ил тод, нээлттэй, шударга, хамт олныг манлайлах, багаар ажиллахыг үйл ажиллагааны үндсэн зарчмаа болгож, төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 3.3.8 Төвийн удирдлага нь Эмнэлгийн тусlamжийн хуулийн 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 4-д заасан гэрээг Аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газартай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10-р зүйлд заасан тусlamж үйлчилгээг худалдан авах гэрээг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулна.
- 3.3.9 Төвийн удирдлага нь Эрүүл мэндийн яам, Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар/ Засаг дарга, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай шууд харилцах эрхтэй бөгөөд бусад хуулийн этгээдээр төлөөлүүлэхгүй.
- 3.3.10 Нөхөрлөлийн гишүүн нь багшлах, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн төрийн бус байгууллагад хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсрان

эрхлэх, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг өөр нөхөрлөлийн гишүүн байхыг хориглоно.

Дөрөв. Төвийн санхүүжилт ба тайлагналт

- 4.1 Төвийн санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, аж ахуй нэгж, байгууллага хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.
- 4.2 Төвийг Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Төсвийн тухай хууль, түүнийг дагаж гарсан тогтоол, тушаал, шийдвэрийн дагуу санхүүжүүлж, хяналт тавина.
- 4.3 Төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлант эдийн засгийн ангилал, зориулалт, санхүүгийн эх үүсвэрээр гаргаж, дараа сарын 05-ны дотор, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор гүйлгээ хийж буй харьялагдах төрийн санд хүргүүлнэ.
- 4.4 Төв нь өөрийн санхүүгийн үйл ажиллагаанд аудитын дүгнэлт, зөвлөмж гаргуулсан байна.
- 4.5 Санхүүгийн зөрчил гаргасан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцсан албан тушаалтан хариуцлага хүлээнэ.

Тав. Төвийн үйл ажиллагааны чиглэл

- 5.1 Төв нь өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт болон тусламж, үйлчилгээний багц, тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг харьялах нутаг дэвсгэрт байгаа хүн бүрд нь харьяалал харгалзахгүйгээр чанартай, хуртэмжтэй, чирэгдэлгүй үзүүлнэ.
- 5.2 Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, хянах, эрүүл мэндийг дэмжих, өвчинеес урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлэх, сэргээн засах үйл ажиллагааг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ хамаарна.
- 5.3 Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн эрэлт, зорилтод бүлгийн хүн амын эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэрэгцээг зөв тодорхойлж, шаардлагатай лавлагаа шатлалын тусламжийн үйлчилгээнд илгээх, эргэх холбоо тогтоох ажлыг хугацаа алдалгүй зохион байгуулна.
- 5.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.
- 5.5 Гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед удирдах байгууллагын шийдвэрийг мөрдэж, тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлнэ.
- 5.6 Харьяалах шатны Засаг дарга, цагдаа, бүртгэлийн байгууллагын дэмжлэгийг авч, эрүүл мэндийн талаарх мэдээллээр ханган хамтарч ажиллана.
- 5.7 Харьяалах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ажиллаж байгаа, төрийн болон төрийн бус байгууллагатай хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчинеес

урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн мэдээ мэдээлэл өгч, мэргэжлийн арга зүйгээр ханган, хамтарч ажиллана.

5.8 Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд иргэн, гэр бүл, олон нийтийг татан оролцуулна.

5.9 Өрхийн эрүүл мэндийн төв нь тусlamж үйлчилгээний аль нэг чиглэлээр (тухайлбал хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, сэргээн засах, ахмадын тусlamж үйлчилгээ гэх мэт) илүү мэргэшсэн байж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн үйлчилэх хүрээний хүн амд анхан шатны тусlamж үйлчилгээг цогц байдлаар хүргэх чиглэлээр төвүүд хамтран ажиллаж болно.

Зургаа. Бусад

6.1 Төв нь төрийн болон орон нутгийн өмчийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу ашиглана.

6.2 Улс орон нутгийн төсөв, хандив, төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн хөрөнгийг аймаг, нийслэлийн Өмчийн харилцааны газарт бүртгүүлнэ.

6.3 Төв нь өөрсдөө хандив болгон, нэмэлт орлогоос авсан өмч хөрөнгийг нөхөрлөлийн өмчид бүртгэнэ.

6.4 Төвийн байрны их засварыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж, холбогдох журмын дагуу тайлан бүртгэлд тусгана.

6.5 Төвийн тогтмол зардлын тодорхой хувийг аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс хариуцна.

6.6 Төв татан буугдсан тохиолдолд талуудын төлөөллийг оролцуулан төвийн хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Өмчийн харилцааны газар, нөхөрлөлийн гишүүд хариуцан гүйцэтгэнэ.

6.7 Харьялах нутаг дэвсгэрт тусlamж, үйлчилгээ үзүүлж буй төвийн болон шинээр төв байгуулах тохиолдолд хэрэгцээтэй байр, хөрөнгө, эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжээр хангах болон санхүүжилтийн асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газартай хамтран шийдвэрлэнэ.

-----xXx-----